

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ХИЛИЙН АНГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Г.Лхагвамаа
Аюулгүй байдлын удирдлага, стратегийн
профессорын багийн профессор, доктор,
дэд профессор, хурандаа

С.Пүрэв-Очир
Дотоод хэргийн их
сургуулийн Удирдлагын
академийн 8012 дугаар
дамжааны суралцагч,
хошууч

Товч агуулга: Энэхүү өгүүллээр мэдээллийн аюулгүй байдал болон төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын асуудлыг онолын үндэстэй судлах, мэдээллийн аюулгүй байдалд төрийн байгууллагын мэдээлэл, хувь хүний мэдээлэл, хэвлэл мэдээлэл хэрхэн нөлөөлөхийг хөндөн таамаглал дэвшүүлж, Хил хамгаалах байгууллагын ангийн албан хаагч, ажилтныг хамруулан мэдээллийн аюулгүй байдалд нөлөөлөх нөлөөллийн шинжилгээ, мэдээллийн аюулгүй байдалд таамаглалаар дэвшүүлсэн 3 хүчин зүйл хамаарлыг тодорхойлохыг судлахыг зорилоо. Судалгаанд оролцсон нийт 40 оролцогчийн өгөгдөлд боловсруулалт хийж шинжлэн, SMART PLS-3.0, SPSS-25.0 программ хангамжийг ашиглаж, хэмжил зүй, хүчин зүйл, замын шинжилгээг хийсэн болно.

Түлхүүр үгс: Мэдээллийн аюулгүй байдал, онол, төрийн байгууллага, шинжилгээ, хувь хүний аюулгүй байдал

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНОЛ АРГА ЗҮЙ

Хүн төрөлхтөн үүсэн бий болсон цагаасаа эхлэн аливаа аюул, занал, эрсдэлээс өөрийгөө хамгаалж ирсэн бөгөөд харин тусгайлан судалж, ирсэн цаг хугацаа нь харилцан адилгүй билээ. Энэ үүднээс авч үзвэл зарим төрлийн тусгай судалгаа, шинжилгээ нь олон зууны түүхтэй, зарим нь ХҮIII-XIX зуунаас явагдсан байдаг бол гол судалгаанууд XX зууны хоёрдугаар хагасаас эрчимтэй явагдаж эхэлсэн байдаг. Хүний эрүүл мэндэд заналхийлсэн аюулыг судалж, өвчинтэй тэмцэх арга хэмжээг боловсруулсан хамгийн эртний шинжлэх ухаануудын нэг бол анагаах ухаан юм. Улмаар аюулын асуудлаар эрчимтэй явагдсан тусгай шинжилгээ, боловсруулалтын чухал чиглэлд аж үйлдвэр, хөдөө аж ахуй, зам тээвэр, эрчим хүчний салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, түүнчлэн галын г.м аюулгүй байдлын судалгаа тооцогдсоор иржээ.

Аюул гэдэг нь өргөн хүрээтэй ойлголт юм. Аюул гэдэг нь сөнөөх, сүйтгэх шинж чанар бүхий объект, хүчин зүйлсийн зүгээс хүн, байгаль, ямар нэгэн зүйлд хор хохирол учруулах магадлалын тухай ойлголт юм. Аюулын нэлээд тодорхой объектод чиглэсэн, түүнийг онилсон хэлбэрийг занал гэж үздэг.¹ Аюул нь логикийн хувьд анхдагч ойлголт юм. Энэ нь хийсвэр, тодорхой, бодитой байж болно. Хийсвэр аюул гэдэг нь аюулгүй байдал тухайн агшинд бодитой болох нөхцөл бүрдээгүй байдлаар хязгаарлагдаж байдаг. Ийм нөхцөл бүрэлдсэн болон тухайн объектод чиглэсэн аюулын дохио өгсөн үед тодорхой аюул болно. Чиглэл, зорилготой үйл ажиллагааны үр дүнд, эсвэл хүмүүсийн бодол, эргэцүүлэлд аяндаа мэдрэгдэж, анхаарал татсан, эсвэл үнэхээр бий болоод байгаа аюул нь занал болж даамжирна. Ингэхээр аливаа аюул нь өөртөө ямар нэгэн байдлаар заналыг дагуулж байдаг ажээ^{1 2}. Бодит амьдрал дээр янз бүрийн аюулууд урьд байсан, одоо ч байгаа, цаашид байсаар байх нь тодорхой юм. Ийм учраас аюулгүй байдлын өнөөгийн агуулгыг "аюулаас бодитойгоор хамгаалагдсан байдал, түүнийг найдвартай сөрөн зогсох чадвар"³ гэж тодорхойлсон байна. Хүн төрөлхтний хөгжлийн бүхий л үед хүмүүс болоод нийгэмд аюул, занал учруулж ирсэн олон төрлийн байнгын эх үүсвэр бий.

Хэл шинжлэлийн болон аюулгүй байдал судлалын эрдэмтэд аливаа объектын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг заавал судлах зүйл болгон өөрсдийн тодорхойлолтыг өгсөн байдаг.

Цэргийн болон хилийн нэр томьёоны тайлбар тольд: Аюул-байгаль орчны доройтол, нийгэм, эдийн засгийн уналт, улс төрийн хямрал зэргээс хамаарч эд хөрөнгө сүйрэх, хүний амь нас эрсдэх, бэртэл гэмтэл авах шалтгаан болох зэргээр хөнөөл учруулж болзошгүй аливаа үзэгдэл, тохиолдол, хүний үйл ажиллагаа. Аюул нь байгалийн, (геологийн, ус цаг уурын, биологийн) болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй (хүрээлэн буй орчны доройтол, технологийн, нийгэм, улс төр) г.м өөр өөр гарал үүсэлтэй байдаг. Аюул нь ирээдүйд заналд шилжих, улмаар сүйтгэл, хохирол учруулах далд нөхцөлийг агуулж байдаг.

Аюул нь гарал үүсэл, үзүүлэх үр нөлөөнөөсөө хамаараад дан, дараалсан, хосолсон хэлбэртэй байдаг. Аюул бүр нь түүний байршил, эрчимжил, давтамж, магадлалаараа өөрийн гэсэн онцлог шинжтэй байдаг⁴ гэсэн бол;

Судлаач Ч.Улаанхүү "аюул - энэ бол сөрөг үйлчлэлийн бодитой оршин тогтнож байгаа боломж, золгүй байдлыг нүүрлэхийг урьдаас мэдрэх боломж, эсхүл нүүрлэх байдал, аль нэг субъектийн ахуй амьдралд нэн чухал объектууд,

¹ Прохожев А.А. Общая теория национальной безопасности. /https://www.studmed.ru/view/prohozhev-a-obschaya-teoriya-nacionalnoy-bezopasnosti_197fc1b77f7f.html/

² Эрдэнэчимэг Б. Аюулгүй байдлын чиг хандлага өөрчлөлт, батлан хамгаалах бодлогод нөлөөлөх нь. Уб., 2016. 10 дахь тал.

³ Бельков О.А. Понятийно-категориальный аппарат концепции национальной безопасности. М., 1994. №3. стр. 91.

⁴ Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн. Цэргийн нэр томьёоны тайлбар толь. Уб., 2014. 56 дахь тал.

байгалийн үнэт зүйлсийг сөнөөх, эсвэл тэдгээрт хор хохирол учруулж унаган төрхийг алдагдуулах, хөгжлийн зам мөрийг хаах боломж бүхий бодитой эсхүл болзошгүй үзэгдэл, үйл явц юм, занал - хэн нэгнийг таагүй байдал, гай зовлонд автагдуулахаар айлган сүрдүүлэх, амлаж андгайлах, илтээр дайсагнагч хүчний зүгээс чиглэл, зорилготой явуулж байгаа аюулын нэн илт, тодорхой, шууд хэлбэр, айдас хүйдэст автоулах замаар аль нэг харилцааны түвшинд давуу байдал олж авах үндсэн зорилготойгоор сөрөг талыг төөрөгдөлд оруулж байгаа арга хэлбэр юм”⁵ гэж тодорхойлжээ.

Аюул нь олон янзын хэлбэрээр оршин тогтнож болно. Аюулын тухай орчин үеийн үзэл баримтлалд тулгуурлан уламжлалт аюул, уламжлалт бус аюул гэж ангилж байна. Уламжлалт бус аюул гэж орчин үед гарч ирсэн шинэ аюулууд тухайлбал терроризм (хорлон сүйтгэх ажиллагаа, хэт даврах ажиллагаа), хар тамхи, хүний наймаа, онц халдварт өвчин, далайн дээрэм, хууль бус цагаачлал, орчны аюулгүй байдал, санхүү, эдийн засаг, мэдээллийн аюулгүй байдалд нүүрлэсэн аюулыг хэлдэг болжээ⁶.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд:

1.1.1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ.

1.1.2. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.

Аюулгүй байдал гэж-олон улсын, улс үндэстний, хамт олны, түүгээр ч барахгүй хувь хүний хэмжээнд түгээмэл хэрэглэгддэг ажил амьдралын амгалан тайван орчин нөхцөлийн тухай ерөнхий ойлголт. Улс үндэсний аюулгүй байдлыг түүний оршин тогтнохын, нийгэм-улс төрийн гэж авч үзэх нь бий. Үндэсний аюулгүй байдал нь хүний, хүнсний, экологийн, удмын сангийн г.м тодотголтой хэрэглэгддэг. Үндэсний аюулгүй байдал нь улс орны үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлж, тал бүрийн баталгаа буй болгоход чиглэсэн төрийн бодлого, төр түүний байгууллага, албан тушаалтнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээр хангагдана. Үндэсний аюулгүй байдлыг нийгэм, улс төрийн, эдийн засгийн, дипломатын, цэргийн, хууль зүйн аргаар дангаар буюу олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хангадаг⁷.

⁵ Улаанхүү Ч. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. Уб., 2014. 69-70 дахь тал.

⁶ Төмөрчулуун Г. Уламжлалт бус аюулын зарим асуудал. Монгол Улсын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. Уб., 2014. 161 дэх тал.

⁷ Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн. “Цэргийн нэр томьёоны тайлбар толь” Уб., 2014. 57 дахь тал.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд “Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ”. “Үндэсний язгуур ашиг сонирхол”-д Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана гэжээ.

Олон улсад аюулгүй байдал нь “safety”, “security” гэсэн нэр томъёогоор илэрхийлэгддэг. “Safety” гэдэг нь аливаа зүйлд хор хохирол учрахаас болон бусад хүсээгүй үр дагавраас хамгаалж аюулгүй байх нөхцөл байдал юм⁸. Мөн аюулгүй байдлын тухай ойлголтод эрсдэл, түүнийг хүлээн зөвшөөрөгдөх төвшин, түүнд хүргэхийн тулд аюулыг хянах асуудлыг хамруулан ойлгодог. Аюулгүй байдал буюу “Safety”-тай холбоотойгоор “Security” буюу “хамгаалалт” (аюулгүй байдлыг хангах, хамгаалах) гэсэн нэр томъёог хамтад нь ихэвчлэн хоршиж, сольж, адилгаж, нэг өгүүлбэрээр, бие биетэй нь зэрэгцүүлэн хэрэглэх нь англи хэлэнд олонтаа⁹

Мэдээллийн аюулгүй байдал гэж мэдээллийн салбарт үндэсний аюулгүй байдлыг хангах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн.

Мэдээллийн аюулгүй байдал гэдэг нь өргөн утгаараа нийгэм, институц, байгууллага, хувь хүний мэдээллийн орчны хамгаалагдсан байдал, явцуу утгаараа ажил хэргийн тасралтгүй чанарыг хангах, эрсдэлийг багасгах, хөрөнгө оруулалтын үр ашиг, бизнесийн боломжийг нэмэгдүүлэхийн тулд мэдээлэл, мэдээлэл харилцаа холбооны орчныг олон янзын аюул, заналхийллээс хамгаалах цогц үйл ажиллагаа юм. Мэдээллийн аюулгүй байдал нь өгөгдөл, мэдээлэл, түүнийг боловсруулах тоног төхөөрөмжийг аюул заналхийллээс хамгаалах, эмзэг, сул талыг нь буруугаар ашиглахаас сэргийлэх үйл ажиллагаа, үйл явц, үйлдлүүд. Мэдээллийн технологи хөгжихийн хэрээр мэдээллийн аюулгүй байдлын эсрэг цахим гэмт хэрэг нэмэгдэж, илрүүлэхэд төвөгтэй олон шинэ төрлүүд бий болж, хуурамч мэдээллийн урсгалыг хязгаарлах боломж хумигдаж байна. Гэсэн хэдий ч мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль, эрх зүйн шинэ орчин, өндөр технологи, дата баазуудыг үр дүнтэй ашиглаж, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэх боломжтой.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.4.үндэсний аюулгүй байдал нь дараахь бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

- Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал

⁸ <https://en.wikipedia.org/wiki/Safety>

⁹ Булган Д. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг, эрх зүйн зохицуулалт. Хууль зүйн докторын зэрэг горилсон диссертаци. УБ., 2017. 16 дахь тал.

- Нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал
- Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал
- Эдийн засгийн аюулгүй байдал
- Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал
- Мэдээллийн аюулгүй байдал
- Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал
- Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал;
- Экологийн аюулгүй байдал.
- Хүнсний аюулгүй байдал гэх мэт агуулгыг багтааж ойлгож болно гэж заасан байдаг.

Хувь хүний мэдээлэл:

2017 оны 12-р сарын 29-нд БНХАУ-ын Стандартчиллын албанаас Мэдээллийн аюулгүй байдлын технологи - Хувийн мэдээллийн аюулгүй байдлын тодорхойлолт (GB/T 35273-2017) ("Үзүүлэлт") гаргасан бөгөөд энэ нь 2018 оны 5-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болно. заавал дагаж мөрдөх журмын дагуу энэ нь кибер аюулгүй байдлын тухай хуультай ("Кибер аюулгүй байдлын тухай хууль") БНХАУ дахь хувийн мэдээллийг хамгаалах гол үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү үйлчлүүлэгчийн шинэчлэлд бид ажилчид болон гуравдагч этгээдээс хувийн мэдээлэл цуглуулахтай холбоотой Үзүүлэлтийн үндсэн шаардлагуудыг авч үздэг. Ийм шаардлага нь БНХАУ дахь бизнесийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх томоохон асуудлуудыг үүсгэдэг. Бид ийм асуудалтай холбоотой зарим удирдамжийг гаргасан байдаг.¹⁰

Төрийн байгууллагын мэдээлэл:

Төр, хувийн хэвшлийн байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын бодлого, дэг, эрсдэлийн удирдлага, дотоод аудит, үнэлгээний чадавхийг бий болгоно. ¹¹

Мэдээллийн аюулгүй байдлын орчин үеийн дэвшилтэт, өртөг багатай шийдлийг зөвхөн эрсдэлийн үнэлгээний үндсэн дээр сонгон ашиглана. Төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектын мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг өндөр түвшинд бэлтгэгдэж, итгэмжлэгдсэн үндэсний мэргэжилтнээр гүйцэтгүүлнэ.¹²

¹⁰ <https://www.nortonrosefulbright.com/en/knowledge/publications/f959f04d/personal-information-security-specification>

¹¹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010.07.15. заалт 3.6.1.7.


¹² Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010.07.15. заалт 3.6.1.8.

Хувь хүний мэдээлэл: Нийгмийн сэтгэл зүй, тогтвортой байдал, хувь хүний ухамсар, ёс зүйд хөндлөнгөөс нөлөөлөх оролдлогыг хязгаарлана. Дайсагнал, ялгаварлан гадуурхах үзэл, үзэн ядалтыг сурталчилсан, дэмжсэн сурталчилгаа, мэдээллийг таслан зогсоох, саармагжуулах чадавхийг бий болгож, үл зөвшөөрөх сэтгэхүйг нийгэмд төлөвшүүлнэ.

Хэвлэл мэдээлэл: Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай хэвлэл мэдээллийн хэрэгсэл үндэсний аюулгүй байдалд харшилсан үйл ажиллагаа явуулбал үйл ажиллагаа явуулах эрхийг нь хягаарлаж болно. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харъяалал нь ил тод байх бөгөөд үйл ажиллагаа нь бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байна. Мэдээллийн хэрэгслээр үндэсний үнэт зүйлийг түлхүү нийтлэх, сурталчлахыг дэмжиж, гадны шашин, соёл, төрийн бодлогыг сурталчилсан агуулгатай мэдээллийг зохистой түвшинд хягаарлана.

Судалгааны ажилдаа дээрх онол, судалгааны ажлуудын үр дүнг дэмжин, мэдээллийн аюулгүй байдалд төрийн байгууллагын мэдээлэл, хувь хүний мэдээлэл, хэвлэл мэдээлэл хэрхэн нөлөөлөх хамаарлыг таамаглал дэвшүүлэн судаллаа.

Зураг 1. Мэдээллийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийн нөлөөлөл



Тайлбар: Судлаачийн санал болгож буй загвар

ТААМАГЛАЛ-1. Төрийн байгууллагын мэдээлэл нь мэдээллийн аюулгүй байдалд эерэгээр нөлөөлнө.

ТААМАГЛАЛ-2. Хувь хүний мэдээлэл нь мэдээллийн аюулгүй байдалд эерэгээр нөлөөлнө.

ТААМАГЛАЛ-3. Хэвлэл мэдээлэл нь мэдээллийн аюулгүй байдалд эерэгээр нөлөөлнө.

Судалгааны үр дүн:


Судалгааг 2022 оны 05 дугаар сарын 10-22-ны өдрүүдэд Хил хамгаалах байгууллагын хилийн ангийн цэргийн алба хаагч, ажилтнуудыг хамруулсан нь судалгааны ажлын сэдвийн хүрээнд нийцсэн гэж үзэж байна.

Чанарын судалгааны арга нь тоон судалгаагаар хэмжигддэг үйл ажиллагаа, үр дүнг мэдээлэх утгыг илтгэдэг. Судалгааны үр дүн нь судлаачдын чиг хандлагыг тодорхойлох, кодлох, дүн шинжилгээ хийх нарийн, системчилсэн аргуудыг ашигладаг онцлогтой тул энэ хүү аргыг сонгосон.

Мэдээллийн аюулгүй байдал, төрийн байгууллагын мэдээлэл, хувь хүний мэдээлэл, хэвлэл мэдээллийн нөлөөллийг судлан үзэхдээ төлөөлөх чадварыг тооцон, Хилийн цэргийн ангийн цэргийн алба хаагч, ажилчдаас түүврийн бүлгийн сонгон судалгааг явуулсан болно.

Судалгаанд нийт 45 оролцогч хамрагдсан ч хүчин төгөлдөр 40 оролцогчийн өгөгдөлд боловсруулалт хийн асуумж бүрээр тоймлон ерөнхий мэдээлэл гаргасан.

Зураг 2. Хэмжил зүйн шинжилгээний үр дүн



Тайлбар: info sec-мэдээллийн аюулгүй байдал, pub-төрийн байгууллагын мэдээлэл, media-хэвлэл мэдээлэл, per info-хувь хүний мэдээлэл

Хүснэгт 1. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Хувьсагч	Асуумж	Далд хувьсагчдын утга	Кронбах альфа	Найдвартай байдлын утга	Дундаж утга
Мэдээллийн аюулгүй байдал	Info sec-1	0.828	0.925	0.944	0.772
	Info sec-2	0.920			
	Info sec-3	0.926			
	Info sec-4	0.916			
	Info sec-5	0.797			
Төрийн байгууллагын мэдээлэл	Media-1	0.925	0.914	0.933	0.736
	Media-2	0.900			
	Media-3	0.887			
	Media-4	0.882			
	Media-5	0.888			
Хувь хүний мэдээлэл	Per info -1	0.498	0.821	0.873	0.587
	Per info -2	0.846			
	Per info -3	0.860			
	Per info -4	0.820			
	Per info -5	0.746			
Хэвлэл мэдээлэл	Pub-1	0.792	0.940	0.954	0.804
	Pub-2	0.901			
	Pub-3	0.867			
	Pub-4	0.776			
	Pub-5	0.941			

Тайлбар: Info sec -мэдээллийн аюулгүй байдал, Media- Төрийн байгууллагын мэдээлэл, Per info- Хувь хүний мэдээлэл, Pub- Хэвлэл мэдээлэл

Судалгааны ажлын хүчин зүйлийн шинжилгээнээс харахад:

Төрийн байгууллагын мэдээлэл хувьсагчийн 5 далд хувьсагч 0.593-0.645 хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга 0.914, найдвартай байдлын утга 0.933, дундаж утга 0.736 байгаа нь найдвартай байдал, дундаж утга сайн байгаа ч, Per info -1 хувь хүний мэдээлэл нь нууцлагдаж чаддаг эсэх зэрэг асуумжид оролцогчид үнэлгээ бага өгсөн тул далд хувьсагч 0.5 нэгжээс бага гарсан.

Хэвлэл мэдээлэл хувьсагчийн 5 далд хувьсагч 0.792-0.941 хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга 0.940, найдвартай байдлын утга 0.954, дундаж утга 0.804 байна.

Мэдээллийн аюулгүй байдлын хувьсагчийн 5 далд хувьсагч 0.797-0.926 хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга 0.925, найдвартай байдлын утга 0.944, дундаж утга 0.772 байна (Хүснэгт 1).

Хүснэгт 2. Замын шинжилгээний үр дүн

№	Таамаглал	Стандарт хазайлт	Т статистик	П үнэ цэнэ	Үр дүн
1	Таамаглал-1. Төрийн байгууллагын мэдээлэл мэдээллийн аюулгүй байдалд эерэгээр нөлөөлнө.	0.248	2.230	0.026	Батлагдсан
2	Таамаглал-2. Хувь хүний мэдээлэл мэдээллийн аюулгүй байдалд эерэгээр нөлөөлнө.	0.158	1.436	0.152	Батлагдаагүй
3	Таамаглал-2. Хэвлэл мэдээлэл мэдээллийн аюулгүй байдалд эерэгээр нөлөөлнө.	0.224	0.069	0.945	Батлагдаагүй

Тайлбар: Судалгааны үр дүн

Замын шинжилгээний үр дүнгээс харахад, төрийн байгууллагын мэдээлэл мэдээллийн аюулгүй байдалд эергээр нөлөөлнө гэсэн таамаглалын хувьд, стандарт хазайлт 0.248, Т статистик үр дүн 2.230, П үнэ цэнэ 0.026 утгатай гарч таамаглал батлагдсан. Хувь хүний мэдээлэл мэдээллийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө таамаглалын хувьд, стандарт хазайлт 0.158, Т статистик үр дүн 1.436, П үнэ цэнэ 0.152 утгатай гарч таамаглал батлагдаагүй, Хэвлэл мэдээлэл мэдээллийн аюулгүй байдалд эерэгээр нөлөөлнө таамаглалын хувьд стандарт хазайлт 0.224, Т статистик үр дүн 0.069, П үнэ цэнэ 0.945 утгатай гарч таамаглал батлагдаагүй юм.

Дүгнэлт

Судалгааны үр дүнд дэвшүүлэн таамагласан нийт гурван таамаглалаас төрийн байгууллагын мэдээлэл нь мэдээллийн аюулгүй байдалд эергээр нөлөөлнө гэсэн таамаглал батлагдсан.

Цаашид мэдээллийн аюулгүй байдалд нөлөөлж байгаа хувьсагчдыг тухайн салбарыг судалсан олон улсын эрдэмтдийн судалгаатай харьцуулан илүү дэлгэрэнгүй судлах нь дараагийн судалгааны ажлын үндэслэл болсон гэж дүгнэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал УБ 2010.

Эрдэнэчимэг Б. Аюулгүй байдлын чиг хандлага өөрчлөлт, батлан хамгаалах бодлогод нөлөөлөх нь. УБ, 2016 он.

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн. Цэргийн нэр томъёоны тайлбар толь. УБ 2014 он

Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966 он

Улаанхүү Ч. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. УБ, 2014 он

Төмөрчулуун Г. Уламжлалт бус аюулын зарим асуудал. Монгол Улсын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. УБ.2014 он

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн. “Цэргийн нэр томъёоны тайлбар толь” УБ.2014 он

Булган Д. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг, эрх зүйн зохицуулалт. Хууль зүйн докторын зэрэг горилсон диссертац. УБ., 2017 он.

Судалгааны үр дүнгийн хавсралт, баримтжуулсан мэдээлэл

20220420.txt *20220420 Purev-Ochir.splsm PLS Algorithm (Run No. 1)

Discriminant Validity

Fornell-Larcker Criterion	Cross Loadings	Heterotrait-Monotrait Ratio (HTMT)	Heterotrait-Monotrait Ratio (HTMT)
Мэдээллийн аюулгүй байдал			
Мэдээллийн аюулгүй байдал	0.879		
Төрийн байгууллагын мэдээлэл	0.689	0.858	
Хувь хүний мэдээлэл	0.577	0.652	0.766
Хэвлэл мэдээлэл	0.546	0.748	0.651
			0.897

20220420.txt *20220420 Purev-Ochir.splsm PLS Algorithm (Run No. 1)

Construct Reliability and Validity

Matrix	Cronbach's Alpha	rho_A	Composite Reliability	Average Variance Extracted (AVE)
Cronbach's Al... Composite Rel... Average Varian...				
Мэдээллийн аюулгүй байдал	0.925	0.944	0.772	
Төрийн байгууллагын мэдээлэл	0.914	0.933	0.736	
Хувь хүний мэдээлэл	0.821	0.873	0.587	
Хэвлэл мэдээлэл	0.940	0.954	0.804	

20220420.txt *20220420 Purev-Ochir.splsm Bootstrapping (Run No. 2)

Path Coefficients

 Mean, STDEV, T-Values, P-Values	 Confidence Intervals	 Confidence Intervals Bias Corrected	 Samples			
		Original Sampl...	Sample Mean (...	Standard Devia...	T Statistics (JO/...	P Values
Төрийн байгууллагын мэдээлэл -> Мэдээллийн аюулгүй байдал		0.552	0.558	0.248	2.230	0.026
Хувь хүний мэдээлэл -> Мэдээллийн аюулгүй байдал		0.227	0.261	0.158	1.436	0.152
Хэвлэл мэдээлэл -> Мэдээллийн аюулгүй байдал		-0.016	-0.017	0.224	0.069	0.945

20220420.txt *20220420 Purev-Ochir.splsm PLS Algorithm (Run No. 1)

Outer Loadings

Matrix	Мэдээллийн а...	Төрийн байгу...	Хувь хүний мээ...	Хэвлэл мэдээ...
info sec-1	0.828			
info sec-2	0.920			
info sec-3	0.926			
info sec-4	0.916			
info sec-5	0.797			
media-1				0.925
media-2				0.900
media-3				0.887
media-4				0.882
media-5				0.888
per info 1			0.498	
per info 2			0.846	
per info 3			0.860	
per info 4			0.820	
per info 5			0.746	
pub-1		0.792		
pub-2		0.901		
pub-3		0.867		
pub-4		0.776		
pub-5		0.941		